



2018 оны 07 дугаар сарын 09
№26 /1031/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
хууль**

**Банкны салбарын тогтвортой
байдлыг хангах тухай**

**Монгол Улсын
хууль**

**Монгол Улсын Их Хурлын
чуулганы хуралдааны дэгийн
тухай хуульд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай**

**Монгол Улсын
Их Хурлын
тогтоол**

**Төрийн өмчөөс аймаг,
нийслэлийн өмчид эд хөрөнгө
шилжүүлэх тухай**

ГАРЧИГ
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

246.	Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай	814
247.	Банкны тухай хуульд /шинэчилсэн найруулга/ нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	826
248.	Зөрчлийн тухай /шинэчилсэн найруулга/ хуульд өөрчлөлт оруулах тухай	827
249.	Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай	828
250.	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	828
251.	Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	833
252.	Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	834

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

253.	Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай	Дугаар 61	834
254.	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай	Дугаар 62	846
255.	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойргийн нөхөн сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай	Дугаар 63	846
256.	Нөхөн болон дахин сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай	Дугаар 64	847
257.	Түр хорооны даргыг сонгох тухай	Дугаар 65	847
258.	Прокурорын зэрэг дэвийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай	Дугаар 66	848
259.	Монгол Улсын 2017 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай	Дугаар 67	849
260.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 68	850



261.	Монгол Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай	Дугаар 69	850
262.	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зарим заалтыг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай	Дугаар 70	852
263.	“Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дугаар 71	853
264.	“Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын 2013 оны 18 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай	Дугаар 72	854
265.	Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 73	854

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 06 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

БАНКНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь банкны салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор банканд хийсэн активын чанарын үнэлгээ, бусад холбогдох хяналт шалгалтын үр дүнд гарсан өөрийн хөрөнгийн дутагдлыг банкны хувьцаа эзэмшигч, бусад хөрөнгө оруулагчаар хангуулах, шаардлагатай бол төрөөс банкныг дахин хөрөнгөжүүлэх, оруулсан хөрөнгийг удирдах, төсөвт буцаан төвлөрүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хууль тогтоомж

2.1.Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хууль тогтоомж нь Төв банк /Монголбанк/-ны тухай хууль¹, Банкны тухай хууль², Өрийн удирдлагын тухай хууль³, Төсвийн тухай хууль⁴, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль⁵, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль⁶, Компанийн тухай хууль⁷, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль⁸, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоос бүрдэнэ.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Банкны системд нөлөө бүхий, дунд хугацаанд хэвийн үйл ажиллагаа явуулах боломжтой банкны өөрийн хөрөнгийн шаардлагыг хангуулах, төрөөс банкныг дахин хөрөнгөжүүлэхтэй холбогдох харилцааг энэ хуулиар зохицуулна.

3.2.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол Банкны тухай хуульд заасны дагуу банканд бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авахтай холбогдох харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

4 дүгээр зүйл.Нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

¹ Төв банк /Монголбанк/-ны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1996 оны 11 дугаарт нийтлэгдсэн.

² Банкны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2010 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

³ Өрийн удирдлагын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2015 оны 09 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Төсвийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 03 дугаарт нийтлэгдсэн.

⁵ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2010 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

⁶ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1996 оны 11 дугаарт нийтлэгдсэн.

⁷ Компанийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 42 дугаарт нийтлэгдсэн.

⁸ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2013 оны 24 дугаарт нийтлэгдсэн.



4.1.1.“банкны активын чанарын үнэлгээ” гэж банканд хийх хяналт шалгалтын хүрээнд банкны активын чанарыг бодитой тогтоох зорилгоор хийх үнэлгээг;

4.1.2.“өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх шаардлагын мэдэгдэл” гэж Монголбанкнаас банканд өөрийн хөрөнгийн шаардлагыг хангуулахаар энэ хуулийн 5.1-д заасны дагуу хүргүүлсэн мэдэгдлийг;

4.1.3.“банкны системд нөлөө бүхий банк” гэж сүүлийн 6 сарын турш банкны системийн нийт активын 5 хувиас дээш хувийг эзэлж байгаа банкиг;

4.1.4.“банкийг шинэчлэх төлөвлөгөө” гэж эдийн засгийн нөхцөл байдлаас үл хамааран банк өөрийн хөрөнгийн шаардлагыг хангахуйц хэмжээнд нэмэгдүүлэх, цаашид тогтмол ашигтай ажиллах, төрөөс оруулсан хөрөнгийг төсөвт буцаан төвлөрүүлэх талаарх стратегийг багтаасан гурван жилийн дэлгэрэнгүй бизнес төлөвлөгөөг;

4.1.5.“хамтран ажиллах гэрээ” гэж төрөөс дахин хөрөнгөжүүлж байгаа банк санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай байгуулсан банкийг шинэчлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хүлээх үүрэг, хамтын ажиллагааны хүрээ, төрөөс оруулсан хөрөнгийг төсөвт буцаан төвлөрүүлэх, банкийг шинэчлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг мэдээлэх болон талуудын бусад эрх, үүргийг тодорхойлсон хэлцлийг;

4.1.6.“дунд хугацаанд банкны хэвийн үйл ажиллагаа явуулах боломжтой” гэж банк хэвийн үйл ажиллагаа явуулах замаар 5 жилийн хугацаанд цаашид төрөөс хөрөнгийн дэмжлэггүйгээр ашигтай ажиллахыг;

4.1.7.“нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө” гэж банкны энгийн хувьцаа, түүнтэй дүйцэхүйц давуу эрхийн хувьцаа, цэвэр ашгаас байгуулсан нөөцийн сан, хуримтлагдсан ашиг алдагдал, нэмж төлөгдсөн энгийн хувьцаа, хандивын хөрөнгө;

4.1.8.“хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгө” гэж энэ хуулийн 4.1.7-д зааснаас бусад давуу эрхтэй хувьцаа, нэмж төлөгдсөн давуу эрхийн хувьцаа, дахин үнэлгээний нэмэгдэл, нийгмийн хөгжлийн сан, хувьцаанд хөрвөх бусад үнэт цаас.

ХОЁРДУГААР БҮЛЭГ БАНКНЫ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ШААРДЛАГЫГ ХАНГУУЛАХ, ХҮСЭЛТ ГАРГАХ, ХҮСЭЛТИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ

5 дугаар зүйл.Банкны өөрийн хөрөнгийн шаардлагыг хангуулах

5.1.Активын чанарын үнэлгээ, бусад холбогдох хяналт шалгалтын үр дүнд банк өөрийн хөрөнгийн шаардлагыг хангаагүй бол Монголбанк энэ талаар банканд нэн даруй мэдэгдэнэ.

5.2.Монголбанк энэ хуулийн 5.1-д заасан мэдэгдлийг хүргүүлснээс хойш ажлын гурван өдрийн дотор банкны өөрийн хөрөнгийн дутагдлын хэмжээг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүдэд хүргүүлнэ.

5.3.Банк энэ хуулийн 5.1-д заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш өөрийн хөрөнгийн шаардлагыг 6 сарын дотор хангана.

6 дугаар зүйл.Банк өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа

6.1.Банк Монголбанкнаас тогтоосон өөрийн хөрөнгийн шаардлагыг төр, төрийн өмчит хуулийн этгээдээс бусад хөрөнгө оруулагчдаас банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийг энгийн хувьцаа, хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийг энгийн хувьцаанд хөрвөх давуу эрхийн хувьцаагаар нэмэгдүүлнэ.

6.2.Банк өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор шинээр гаргасан нэг болон хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөд тооцогдох санхүүгийн хэрэгслийг шууд болон шууд бусаар өөрөө худалдаж авах, санхүүжүүлэхийг хориглоно.

6.3.Банк энэ хуульд заасан өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор шинээр гаргасан нэг болон хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөд тооцогдох санхүүгийн хэрэгслийг зээл, эсхүл ямар нэг үүрэг амлалтын хүрээнд барьцаалахыг хориглоно.

6.4.Банк энэ хуульд заасан өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор гаргасан хувьцааг гадаад болон дотоодын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аливаа хуулийн этгээд, нийгмийн даатгалын сан, нутгийн өөрөө удирдах байгууллагад худалдахыг хориглоно.

7 дугаар зүйл.Дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргах, түүнийг хянан шийдвэрлэх

7.1.Банк энэ хуулийн 5.3-т заасан хугацаанд бусад хөрөнгө оруулагчдаас өөрийн хөрөнгийн шаардлагыг бүрэн хангах боломжгүй гэж үзвэл дахин хөрөнгөжүүлэх хүсэлтийг банкиг шинэчлэх төлөвлөгөөний хамт нэн даруй, эсхүл энэ хуулийн 5.3-т заасан хугацаанаас 30 хоногийн өмнө Монголбанканд гаргана.

7.2.Дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргах банк энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан шалгуурыг бүрэн хангасан байна.

7.3.Монголбанк банкиг шинэчлэх төлөвлөгөөг сайжруулах, шинэчлэх арга хэмжээ авах, нэмэлт баримт бичиг, мэдээлэл ирүүлэхийг тухайн банкнаас шаардаж болно.



7.4.Дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргах, банкийг шинэчлэх төлөвлөгөөний агуулга, загвар, тус төлөвлөгөөнд тавих нөхцөл, шаардлага, журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Монголбанк батална.

7.5.Дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргасан банк нь дунд хугацаанд банкны хэвийн үйл ажиллагаа явуулах боломжтой, банкны системд нөлөө бүхий, энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан шалгуурыг бүрэн хангасан эсэхийг Монголбанк нэг сарын дотор хянан баталгаажуулна.

7.6.Энэ хуулийн 7.5-д заасан шаардлага хангасан гэдгийг Монголбанкнаас тодорхойлсон бол тухайн банкийг дахин хөрөнгөжүүлэх шаардлагатай эсэх талаарх саналыг энэ хуулийн 8.1.3-т заасан төлөвлөгөөний хамт санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад нэн даруй хүргүүлнэ.

7.7.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн төрөөс банкийг дахин хөрөнгөжүүлэх саналыг ажлын 3 өдрийн дотор Засгийн газарт хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ТӨРӨӨС БАНКИЙГ ДАХИН ХӨРӨНГӨЖҮҮЛЭХ

8 дугаар зүйл.Төрөөс банкийг дахин хөрөнгөжүүлэх нөхцөл

8.1.Төрөөс банкийг дахин хөрөнгөжүүлэхээс өмнө банк доор дурдсан шаардлагыг хангасан байна:

8.1.1.банк бусад эх үүсвэр, хөрөнгө оруулагчаас энэ хуулийн 5.3-т заасан хугацааны дотор өөрийн хөрөнгийн шаардлагыг бүрэн хангах боломжгүй;

8.1.2.тухайн банкийг төрөөс дахин хөрөнгөжүүлэх нь банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахад зайлшгүй шаардлагатай гэж Монголбанк дүгнэсэн;

8.1.3.Монголбанкнаас банкийг шинэчлэх төлөвлөгөөг зөвшөөрсөн;

8.1.4.банкны системд нөлөө бүхий, дунд хугацаанд банкны хэвийн үйл ажиллагаа явуулах, тогтвортой ашигтай ажиллах боломжтой гэж Монголбанк дүгнэсэн;

8.1.5.активын чанарын үнэлгээ, бусад холбогдох хяналт шалгалтын үр дүнд Монголбанкнаас шаардсаны дагуу эрсдэлийн тусгай болон ерөнхий санг байгуулсан;

8.1.6.активын чанарын үнэлгээ, бусад холбогдох хяналт шалгалтын үр дүнгээр тогтоосон банкны алдагдлыг банкны тухайн үеийн өөрийн хөрөнгөөр санхүүгийн хариуцлага хүлээлгэсэн хувьцаа эзэмшигчдийн хурлын хүчин төгөлдөр шийдвэр гарсан байх;

8.1.7.төрөөс банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийг дахин хөрөнгөжүүлэх шаардлагатай бол хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийг нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөд урьдчилан хөрвүүлсэн байх;

8.1.8.энэ хуулийн 8.1.6-д заасан хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр нэгдүгээр зэрэглэлийн болон хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийг хангалттай хэмжээгээр бууруулсан болохыг Монголбанк тодорхойлсон;

8.1.9.банк хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийг нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөд хөрвүүлэх үнийг Монголбанкнаас зөвшөөрсөн;

8.1.10.энэ хуулийн 7.1-д заасан хүсэлт гаргасан банк санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулахыг зөвшөөрсөн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарсан.

8.2.Банкны системд нөлөө бүхий, дунд хугацаанд банкны хэвийн үйл ажиллагаа явуулах, тогтвортой ашигтай ажиллах боломжтой банк нь энэ хуулийн 5.3-т заасан хугацаанд энэ хуулийн 8.1-т заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд Монголбанк тус шаардлагыг нэг сарын дотор хангуулахаар Банкны тухай хуульд заасан албадлагын арга хэмжээг банканд авна.

8.3.Монголбанк энэ хуулийн 8.2-т заасан арга хэмжээг авч хэрэгжүүлж, энэ хуулийн 8.1-т заасан шаардлагыг бүрэн хангасан гэж үзсэн тохиолдолд энэ хуульд заасны дагуу төрөөс банкнийг дахин хөрөнгөжүүлж болно.

8.4.Энэ хуулийн 8.2-т заасан албадлагын арга хэмжээ авсан банканд төрөөс банкнийг дахин хөрөнгөжүүлэх сүүлийн хугацаа энэ хуулийн 5.3-т зааснаас хойш нэг сарын хугацаанд байна.

9 дүгээр зүйл.Төрөөс банкнийг дахин хөрөнгөжүүлэх хэлбэр

9.1.Төрөөс банкнийг дараах хэлбэрээр дахин хөрөнгөжүүлж болно:

9.1.1.зах зээлийн нөхцөлтэй Засгийн газрын үнэт цаас;

9.1.2.мөнгөн хөрөнгө.



10 дугаар зүйл. Төрөөс банкнийг дахин хөрөнгөжүүлэх

10.1. Энэ хуулийн 7.1-д заасан хүсэлт гаргаж, шаардлага хангасан банк нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулна.

10.2. Төрөөс банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийг энгийн хувьцаа, хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийг хувьцаанд хөрвөх хоёрдогч өглөг хэлбэрээр тухайн банкны өөрийн хөрөнгийн шаардлагыг хангахуйц хэмжээнд нэмэгдүүлнэ.

10.3. Энэ хуулийн 8.1-д заасан шаардлагыг хангасан банк нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн дутагдлыг бусад хөрөнгө оруулагчаас бүрдүүлж чадаагүй бол төр тухайн банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн дутагдсан хэсгийг бүрдүүлнэ.

10.4. Бусад хөрөнгө оруулагч нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн дутагдлын 50-аас багагүй хувийг бүрдүүлсэн тохиолдолд төрөөс тухайн банкны нэгдүгээр болон хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийн дутагдлын үлдэх хэсгийг бүрдүүлнэ.

10.5. Бусад хөрөнгө оруулагч нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн дутагдлын 50-аас доош хувийг бүрдүүлсэн тохиолдолд төрөөс тухайн банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн дутагдлын үлдэх хэсгийг, харин хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийн дутагдлын 50 хувийг энгийн хувьцаагаар, үлдэх 50 хувийг хувьцаанд хөрвөх хоёрдогч өглөг хэлбэрээр бүрдүүлнэ.

10.6. Банк зөвхөн хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх хүсэлт гаргасан бол төрөөс хувьцаанд хөрвөх хоёрдогч өглөг хэлбэрээр нэмэгдүүлнэ.

10.7. Банк өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор нээлттэй хэлбэрээр хувьцаа гаргасан бол төрөөс нээлттэй зах зээл дээр арилжаалагдсан үнээр хөрөнгө оруулна.

10.8. Банк өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор шинээр хувьцаа хаалттай хэлбэрээр гаргаж бусад хөрөнгө оруулагчид хувьцааны 50-аас багагүй хувьд хөрөнгө оруулсан бол төр бусад хөрөнгө оруулагчтай тохиролцсон үнээр тухайн банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн дутагдлын үлдэх хэсэгт хөрөнгө оруулна.

10.9. Банк өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор шинээр хувьцаа хаалттай хэлбэрээр гаргаж бусад хөрөнгө оруулагчид хувьцааны 50-аас бага хувьд хөрөнгө оруулсан бол санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголбанкны Ерөнхийлөгч хамтарч тогтоосон дээд үнээс илүү үнээр хөрөнгө оруулахгүй.

10.10.Энэ хуульд заасан хувьцаанд хөрвөх хоёрдогч өглөг, давуу эрхийн хувьцааны нөхцөлийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголбанкны Ерөнхийлөгч хамтран баталсан журмаар тогтооно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БАНКАНД ТӨРӨӨС ОРУУЛСАН ХӨРӨНГИЙГ УДИРДАХ, ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

11 дүгээр зүйл.Банканд төрөөс оруулсан хөрөнгийг удирдах

11.1.Банканд төрөөс оруулсан хөрөнгийн эрхийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зах зээлийн зарчмыг баримтлан үр ашигтай хэлбэрээр удирдаж, хэрэгжүүлнэ.

11.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төрөөс дахин хөрөнгөжүүлсэнтэй холбоотойгоор дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.2.1.энэ хуульд заасан эрхээ хэрэгжүүлэх зорилгоор төрөөс банкнийг дахин хөрөнгөжүүлэхээс өмнө энэ хуулийн 10.1-д заасан гэрээг байгуулах;

11.2.2.Компанийн тухай хууль болон энэ хуульд заасны дагуу банкны хувьцаа эзэмшигчийн эрхийг эдлэх;

11.2.3.банканд төрөөс оруулсан хөрөнгийг хамтран ажиллах гэрээ, банкны дүрэм, зохих хууль тогтоомжийн дагуу хэсэгчлэн болон бүхэлд нь худалдах;

11.2.4.банканд төрөөс оруулсан хөрөнгийг худалдах, тус хөрөнгийг төсөвт буцаан төвлөрүүлэх төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх;

11.2.5.энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан банканд төрөөс оруулсан хөрөнгийг төсөвт буцаан төвлөрүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх;

11.2.6.дахин хөрөнгөжүүлсэн банкны үйл ажиллагааны болон оруулсан хөрөнгийн талаарх мэдээллийг хагас жил тутамд Засгийн газарт тайлагнаж, тайланг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлд хүргүүлэх;

11.2.7.энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан шаардлага хангасан төрийг төлөөлөх нэг төлөөлөгчийг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд сонгуулахаар томилох;

11.2.8.тухайн банканд төрийн эзэмшиж байгаа хувьцааны хэмжээнээс хамааран төлөөлөн удирдах зөвлөлийн бусад гишүүнийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Монголбанкны зөвшөөрлөөр сонгуулахаар томилох.



11.3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуульд өөрөөр заагаагүй бол хувьцаа эзэмшигчдийн хуралд өөрийн эзэмшлийн хувьцааны саналын эрхийг эдлэх бөгөөд төрийн эзэмшлийн хувьцаа банкны нийт хувьцааны 10 хувиас дээш тохиолдолд банкны хувьцаа эзэмшигчдийн хурлын дараах тогтоол, шийдвэрт хориг тавих эрхтэй:

11.3.1.банкны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах;

11.3.2.банкны өөрийн хөрөнгийн хэмжээг өөрчлөх;

11.3.3.банкийг нэгтгэх, нийлүүлэх, хуваах, өөрчлөн байгуулах, татан буулгах;

11.3.4.банкийг шинэчлэх төлөвлөгөөний хэрэгжилт.

11.4.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл, Монголбанкттай төрөөс дахин хөрөнгөжүүлсэн банкны талаар мэдээлэл харилцан солилцох, мэдээллийн нууцыг задруулахгүй байх талаар гэрээ байгуулна.

12 дугаар зүйл.Дахин хөрөнгөжүүлсэн банкны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төрийг төлөөлөх төлөөлөл

12.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дахин хөрөнгөжүүлсэн банканд төрөөс оруулсан хөрөнгийн бүрэн эрхийг өөрийн томилсон энэ хуулийн 11.2.7-д заасан төлөөлөгчөөр дамжуулан хэрэгжүүлнэ.

12.2.Дахин хөрөнгөжүүлсэн банканд төрийг төлөөлөн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллах энэ хуулийн 11.2.8-д заасан бусад гишүүн нь доор дурдсан шалгуурыг хангасан байна:

12.2.1.Банкны тухай хуульд заасан банкны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, хараат бус гишүүнд тавих шалгуурыг хангасан;

12.2.2.сүүлийн таван жилийн хугацаанд төрийн улс төрийн болон захиргааны албан тушаалтан, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа банкны эрх бүхий албан тушаалтан байгаагүй;

12.2.3.тухайн банкны хувьцааг эзэмшдэггүй.

12.3.Дахин хөрөнгөжүүлсэн банканд энэ хуулийн 11.2.8-д заасан төлөөлөн удирдах зөвлөлд ажиллах гишүүнд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 5, 6 дахь хэсэг хамаарахгүй.

12.4.Дахин хөрөнгөжүүлсэн банканд төрийг төлөөлөн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллах энэ хуулийн 11.2.7-д заасан төлөөлөгч нь доор дурдсан шалгуурыг хангасан байна:

12.4.1.Банкны тухай хуульд заасан банкны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, хараат бус гишүүнд тавих шалгуурыг хангасан;

12.4.2.сүүлийн таван жилийн хугацаанд төрийн улс төрийн албан тушаалтан, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа банкны эрх бүхий албан тушаалтан байгаагүй;

12.4.3.тухайн банкны хувьцааг эзэмшдэггүй.

12.5.Төр банкны нийт хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшдэг бол төлөөлөн удирдах зөвлөлд энэ хуулийн 12.1-т заасан төрийг төлөөлөх этгээд дараах нэмэлт тусгай эрхийг эдэлнэ:

12.5.1.төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг зарлан хуралдуулах санал гаргах;

12.5.2.энэ хуулийн 11.3-т заасан төлөөлөн удирдах зөвлөлөөс гарсан аливаа шийдвэрт хориг тавих.

12.6.Банкны төлөөлөн удирдах зөвлөлд энэ хуулийн 12.1-т заасан төрийг төлөөлөх этгээд өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ тухайн банкны бие даасан байдлыг эрхэмлэнэ.

12.7.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Монголбанкны төлөөллийн 5 гишүүн бүхий нэр дэвшүүлэх хорооноос банкны төлөөлөн удирдах зөвлөлд энэ хуулийн 11.2.8-д заасан төрийг төлөөлөх бусад гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалт хийх замаар санал болгоно.

12.8.Энэ хуулийн 11.2.7-д заасан төлөөлөгч нь банкны хэвийн үйл ажиллагаа, харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашиг, банкны хөрвөх чадвар, төлбөрийн чадварыг алдагдуулах талаар төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан аливаа шийдвэрийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Монголбанканд мэдээлэх үүрэгтэй.

12.9.Энэ хуулийн 11.2.8-д заасан бусад гишүүн нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас чиглэл авахгүй, бие даасан байдлаар банкны төлөөлөн удирдах зөвлөлд шийдвэр гаргана.

12.10.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг хоёр жилийн хугацаатай томилох бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг доор дурдсан тохиолдолд хугацаанаас нь өмнө дуусгавар болгоно:

12.10.1.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь банкны хувьцаа эзэмшигч, эсхүл банкны ажилтан болсон бол;

12.10.2.эрүүл мэндийн болон бусад шалтгааны улмаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлт гаргасан;



12.10.3.эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн;

12.10.4.ашиг сонирхлын зөрчил үүссэн.

12.11.Банкны гүйцэтгэх удирдлагыг Компанийн тухай хууль болон Банкны тухай хуульд заасны дагуу банкны төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр томилж, чөлөөлнө.

13 дугаар зүйл.Банканд төрөөс оруулсан хөрөнгийг төсөвт буцаан төвлөрүүлэх

13.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн банканд төрөөс оруулсан хөрөнгийг төсөвт буцаан төвлөрүүлэх төлөвлөгөөг Монголбанкны саналыг харгалзан баталж, хэрэгжүүлнэ.

13.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 13.1-д заасан төлөвлөгөөний дагуу тухайн банканд төрөөс оруулсан хөрөнгийг энэ хууль хүчин төгөлдөр болсноос хойш таван жилийн дотор төсөвт буцаан төвлөрүүлнэ.

13.3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь банканд төрөөс оруулсан хөрөнгийг нийтэд нээлттэй болон хаалттай хэлбэрээр худалдаж болно.

13.4.Энэ хуулийн 13.1-д заасан төлөвлөгөөний хүрээнд банканд төрөөс оруулсан хөрөнгийг худалдах үнийг төр тус банкны хувьцааг худалдаж авсан үнэ, эсхүл тухайн үеийн зах зээлийн үнээр тогтооно.

13.5.Төрөөс дахин хөрөнгөжүүлсэн банканд төрөөс оруулсан хөрөнгийг удирдах, хянах, төсөвт буцаан төвлөрүүлэхтэй холбогдох журмыг Монголбанкны саналыг үндэслэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

ТАВДУГААР БҮЛЭГ ТӨРӨӨС ДАХИН ХӨРӨНГӨЖҮҮЛСЭН БАНКАНД ХИЙХ ХЯНАЛТ ШАЛГАЛТ

14 дүгээр зүйл.Төрөөс дахин хөрөнгөжүүлсэн банканд хийх Монголбанкны хяналт шалгалт

14.1.Төрөөс дахин хөрөнгөжүүлсэн банканд Монголбанк дараах байдлаар хяналт шалгалт хийнэ:

14.1.1.банкийг шинэчлэх төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, биелэлтийг хангуулах, хугацаатай үүрэг, даалгавар өгөх, хуульд заасан шаардлагатай арга хэмжээ авах, шийдвэр гаргах;

14.1.2.төрөөс дахин хөрөнгөжүүлсэн банк энэ хуульд заасан үүргээ биелүүлээгүй бол Монголбанк хуульд заасан хяналт шалгалтын бүрэн эрхээ хэрэгжүүлэх, албадлагын арга хэмжээ авах.

14.2.Төрөөс дахин хөрөнгөжүүлсэн банкны төлөөлөн удирдах зөвлөл банкныг шинэчлэх төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх тайланг Монголбанканд хүргүүлээгүй, эсхүл уг төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй, хэрэгжүүлэхээс татгалзсан бол Монголбанк, Банкны тухай хуулийн 48.1.12-48.1.14-д заасан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

14.3.Төрөөс дахин хөрөнгөжүүлсэн банкнаас төрийн улс төрийн албан тушаалтан, улс төрийн нам, түүний холбогдох болон харилцан хамаарал бүхий этгээдэд шинээр зээл, санхүүжилт олгохыг хориглоно.

14.4.Төрөөс дахин хөрөнгөжүүлсэн банканд Монголбанкнаас аливаа нэмэлт шаардлага, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоож болно.

14.5.Төрөөс дахин хөрөнгөжүүлсэн банк хувьцааны ногдол ашгийг зөвхөн Монголбанкны зөвшөөрлөөр хуваарилж болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ БУСАД

15 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

15.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтан, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд⁹ заасан хариуцлага хүлээлгэнэ.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

⁹ Зөрчлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 06 дугаар
сарын 22-ны өдөр

Улаанбаатар
хот

БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Банкны тухай хуулийн 43 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 43.6 дахь хэсэг нэмсүгэй:

“43.6.Монголбанк хуульд заасан албадлагын арга хэмжээ авах, хяналт шалгалт хийх журмыг батална.”

2 дугаар зүйл.Банкны тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Төв банк /Монголбанк/-ны тухай хууль,” гэсний дараа “Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хууль,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Банкны тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/44 дүгээр зүйлийн 44.4 дэх хэсэг:

44.4.Энэ хуулийн 44.1-д заасан нэгдсэн хяналт шалгалтыг дараах байдлаар хийнэ:

44.4.1.нэгдсэн хяналт шалгалтад хамруулах шаардлагатай банкны нэгдлийн холбогдох хэсгийг тодорхойлох;

44.4.2.энэ хуулийн 44.4.1-д заасан хэсэгт хамаарах банкны нэгдэлд оролцогчдын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, мэдээлэлд үндэслэн тэдгээрийн санхүү, төлбөрийн чадвар, хоорондын хөрөнгийн урсгал, нэг оролцогчоос нөгөөд оруулсан хөрөнгө, өглөг, авлага, зээл, банкны нэгдлийн оролцогч хоорондын санхүүгийн бусад хэлцэл, гүйлгээний хамаарал болон банкны нэгдлийн хэмжээнд үүсч болзошгүй эрсдэлийг тодорхойлох;

44.4.3.банк, банкны нэгдлийн оролцогч, эсхүл банкны нэгдлийн хэмжээний санхүү, төлбөрийн чадварын байдалд санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагаас тавьж байгаа зохистой харьцааны болон бусад шаардлагыг хангаж байгаа эсэхийг дангаар нь болон нэгдсэн байдлаар тогтоож, үнэлэлт, дүгнэлт өгөх.

**2/45 дугаар зүйлийн 45.4 дэх хэсэг:**

45.4.Энэ хуульд нийцүүлэн холбогдох этгээдийн нэгдлийн оролцогчийг тодорхойлох зорилгоор Монголбанк, банкны гаргасан хүсэлтийн дагуу Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэдээлэл өгнө.

4 дүгээр зүйл.Банкны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2, 30.3 дахь хэсгийн “онцгой дэглэм тогтоосон” гэснийг “банкны нөхцөлт удирдлага хэрэгжүүлсэн” гэж, 66 дугаар зүйлийн 66.3 дахь хэсгийн “62.2-т” гэснийг “66.2-т” гэж, тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Банкны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсгийн “нэгдлийн оролцогч” гэснийг, 43 дугаар зүйлийн 43.2.1, 43.2.3, 43.2.12 дахь заалтын “энэ” гэснийг, 52 дугаар зүйлийн 52.1.1 дэх заалтын “гүйцэтгэх” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 06 дугаар
сарын 22-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН
НАЙРУУЛГА/ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 11.3 дугаар зүйлийн 14 дэх хэсгийн “Банкны тухай хуулиар” гэснийг “Банкны тухай хууль тогтоомжоор” гэж, 15 дахь хэсгийн “Банкны тухай хууль” гэснийг “Банкны тухай хууль тогтоомж” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 06 дугаар
сарын 22-ны өдөр

Улаанбаатар
хот

ӨРИЙН УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Өрийн удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.1.7 дахь заалт нэмсүгэй:

“12.1.7.Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуульд заасны дагуу төрөөс банкныг дахин хөрөнгөжүүлэх”.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 06 дугаар
сарын 29-ний өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/9¹ дүгээр зүйлийн 9^{1.9} дэх хэсэг:

“9^{1.9}.Төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн зүйл, хэсэг, заалтыг уялдуулах, найруулга, үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй саналыг багцлан нэг санал хураалт явуулж болно.”

2/10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг:

“10.3.Улсын Их Хурлын Тамгын газар хэлэлцэж байгаа асуудлын онцлогийг харгалзан төсөл, тодорхой асуудлыг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх “Хуралдаан удирдах дараалал”-ыг бэлтгэж, хуралдаан даргалагчид өгөх бөгөөд хуралдаан даргалагч уг дарааллын дагуу нэгдсэн хуралдааны үйл ажиллагааг зохион байгуулна.”

3/10¹ дүгээр зүйлийн 10¹.1.4 дэх заалт:

“10¹.1.4.гишүүн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдолгүй үг хэлсэн бол хуралдаан даргалагч нэг удаа сануулж, сануулгыг биелүүлээгүй бол тухайн үг хэлэх хугацааг дуусгавар болгох;”

4/19 дүгээр зүйлийн 19.6 дахь хэсэг:

“19.6.Засгийн газар Хууль тогтоомжийн тухай хуулийн 21.13-т заасан дүгнэлт гаргасан бол уг дүгнэлтийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 19.3.2-т заасан санал, дүгнэлтийн дараа 10 минутад багтаан танилцуулна. Засгийн газрын дүгнэлттэй холбогдуулан гишүүн асуулт асууж, үг хэлэхгүй.”

5/23 дугаар зүйлийн 23.1.3 дахь заалт:

“23.1.3.энэ хуулийн 23.1.1-д заасан танилцуулгатай холбогдуулан гишүүд асуулт асуух.”

6/32¹ дүгээр зүйл:

**“32¹ дүгээр зүйл.Үндсэн хуулийн цэцийн тогтоолоор хууль,
Улсын Их Хурлын бусад шийдвэр хүчингүй
болсонтой холбогдуулан холбогдох хууль,
Улсын Их Хурлын бусад шийдвэрт нэмэлт,
өөрчлөлт оруулах журам**

32¹.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу Цэцийн тогтоолоор хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг хүчингүй болгосон бол Улсын Их Хурал Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрт зохих нэмэлт, өөрчлөлтийг оруулна.

32¹.2.Цэцийн тогтоолыг чуулганы үеэр хүлээн авсан бол ажлын 15 өдрийн дотор, чуулганы чөлөөт цагт хүлээн авсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш ажлын 15 өдрийн дотор холбогдох Байнгын хороо энэ хуулийн 32¹.1-д заасан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийг боловсруулж, нэгдсэн хуралдаанд оруулах бөгөөд уг төслийн талаар Засгийн газар, холбогдох бусад байгууллагаас санал авахыг шаардахгүй.”

7/48¹ дүгээр зүйл:

“48¹ дүгээр зүйл.Мэдээлэл сонсох



48¹.1.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19.2.7-д заасан мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтан Байнгын хороонд ирүүлнэ.

48¹.2.Энэ хуулийн 48¹.1-д заасан мэдээллийг тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүн, холбогдох байгууллагын дарга, эсхүл тэдгээрийн орлогч хийнэ.

48¹.3.Байнгын хороо мэдээллийг сонсох үед гишүүд асуулт асууж, үг хэлж болно.

48¹.4.Байнгын хороо тухайн мэдээллийг сонсоод шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах талаар чиглэл өгч болно.”

8/53 дугаар зүйлийн 53.1.4 дэх заалт:

“53.1.4.Улсын Их Хурал энэ хуулийн 53.1.3-т заасан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн эцсийн найруулгатай танилцах үед Улсын Их Хурлын гишүүний гаргасан найруулга, үг хэллэгийн засварыг хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр оруулах.”

2 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэгт “Байнгын хорооны хуралдааны санал хураалтыг бусад Байнгын хорооны хуралдаан, нэгдсэн хуралдааны санал хураалттай давхцуулахгүйгээр зохион байгуулна.” гэсэн 2 дахь өгүүлбэр, 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсэгт “Завсарлагын хугацаанд нэгдсэн болон Байнгын, дэд, түр хорооны хуралдаанаар тухайн асуудлаар хэлэлцүүлэг явуулахгүй.” гэсэн 4 дэх өгүүлбэр, 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “гар утас” гэсний дараа “, бусад хөдөлгөөнт төхөөрөмж” гэж, 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэгт “Тайлбар хийж, асуултад хариулж байгаа албан тушаалтан үнэн зөв мэдээлэл өгөх, асуултад бүрэн хариулах үүрэгтэй.” гэсэн 3 дахь өгүүлбэр, 9¹ дүгээр зүйлийн 9¹.2 дахь хэсэгт “Хуралдааны ирцэд бүртгүүлэх, асуулт асуух, үг хэлэх, цахим тоолуураар санал өгөхөд биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-өөр идэвхэждэг систем бүхий цахим тоолуурыг ашиглана.” гэсэн 2 дахь өгүүлбэр, 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт “Хэлэлцэх асуудалтай холбогдолгүй болон хууль зөрчсөн асуудлаар санал гаргасан бол санал хураалт явуулахгүй.” гэсэн 2 дахь өгүүлбэр, 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалтын “өргөх” гэсний дараа “, насаар хамгийн ахмад гишүүн гишүүний тангараг унших боломжгүй бол насаар ахмад дараагийн гишүүн гишүүний тангаргийг уншиж бусад гишүүд нь давтан хэлж тангараг өргөх” гэж, мөн зүйлийн 11.2 дахь хэсэгт “Насаар хамгийн ахмад гишүүн даргалах боломжгүй бол насаар ахмад дараагийн гишүүн даргална.” гэсэн 2 дахь өгүүлбэр, мөн зүйлийн 11.3 дахь хэсэгт “Тангараг өргөхтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж,

үг хэлэхгүй.” гэсэн 2 дахь өгүүлбэр, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Дэд хорооны бүрэлдэхүүнд орсон гишүүн харьяалах Байнгын хорооны бүрэлдэхүүнээс гарвал тухайн дэд хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлөх тухай тогтоол батлагдсанд тооцно.” гэсэн 2 дахь өгүүлбэр, 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсгийн “тэдгээрийг” гэсний дараа “анхны хэлэлцүүлгийн шатанд” гэж, 21 дүгээр зүйлийн 21.14 дэх хэсгийн “санал хурааж” гэсний дараа “болох бөгөөд” гэж, 32 дугаар зүйлийн 32.3.6 дахь заалтын “тогтоол” гэсний дараа “бусад шийдвэр,” гэж, 53 дугаар зүйлийн 53.9 дэх хэсгийн “Үндсэн хуульд” гэсний өмнө “Монгол Улсын” гэж, “ээлжит” гэсний дараа “болон ээлжит бус” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг:

“20.2.Хуульд өөрчлөлт оруулах тухай төслийг хэлэлцэхдээ хууль санаачлагчийн өргөн мэдүүлээгүй хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр болон төсөлд тусгагдаагүй зүйл, хэсэг, заалтад өөрчлөлт оруулах тухай санал, дүгнэлт гаргахыг хориглоно.”

2/22 дугаар зүйлийн 22.6 дахь хэсэг:

“22.6.Нэгдсэн хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед Байнгын хорооны хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлгийг дахин явуулах шаардлагатай гэж гишүүдийн олонхи үзсэн бол төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороонд шилжүүлнэ.”

4 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.10 дахь хэсгийн “Үндсэн хуулийн” гэснийг “Монгол Улсын Үндсэн хуулийн” гэж, “Үндсэн хуульд” гэснийг “Монгол Улсын Үндсэн хуульд” гэж, 5 дугаар зүйлийн 5.1, 5.2 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалтын “Улсын Их Хурлын” гэснийг “Монгол Улсын Их Хурлын” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтын “байх” гэснийг “байх бөгөөд нэмэлт хариулт, тайлбар хангалтгүй гэж үзвэл тухайн гишүүний саналаар 2 хүртэл удаа тус бүр 1 минутаас илүүгүй хугацаагаар дахин нэмэлт асуулт асууж, тайлбар авах” гэж, 10¹ дүгээр зүйлийн 10¹.1.4 дэх заалтын дугаарыг 10¹.1.5 гэж, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “Улсын Их Хурлын тухай” гэснийг “Монгол Улсын Их Хурлын тухай” гэж, 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.2 дахь заалт, 18, 19 дүгээр зүйлийн гарчиг, 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.3.5 дахь заалтын “төслийн үзэл баримтлалыг”



гэснийг “төслийг” гэж, 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийн “бөгөөд хэлэлцэх эсэх” гэснийг “бөгөөд үзэл баримтлалыг дэмжих эсэх” гэж, мөн зүйлийн 18.5 дахь хэсгийн “санал, дүгнэлтийг” гэснийг “саналыг” гэж, 19 дүгээр зүйлийн 19.3.6 дахь заалтын “төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн бол төслийг” гэснийг “үзэл баримтлалыг дэмжих нь зүйтэй гэж үзсэн бол төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон” гэж, мөн зүйлийн 19.3.7 дахь заалтын “төслийг хэлэлцэхийг” гэснийг “төслийн үзэл баримтлалыг” гэж, “төслийг хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн бол” гэснийг “төслийн үзэл баримтлалыг дэмжихгүй гэж үзсэн бол төслийг” гэж, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “Шинэ” гэснийг “Анхдагч” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “Энэ хуулийн” гэснийг “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн” гэж, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн “5” гэснийг “4” гэж, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 37.4-т” гэснийг “Төсвийн тухай хуулийн 8.10.3-т” гэж, 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсгийн “2 хариултын томъёоллыг” гэснийг “хариултын хувилбарыг” гэж, 31 дүгээр зүйлийн 31.5 дахь хэсгийн “хүлээн зөвшөөрөх” гэснийг “хүлээн авах” гэж, мөн зүйлийн 31.8 дахь хэсгийн “хүлээн зөвшөөрсөн” гэснийг “хүлээн авсан” гэж, “хүчингүй болгож” гэснийг “хүчингүй болгох” гэж, 32 дугаар зүйлийн 32.3.5 дахь заалтын “зөвшөөрсөн бол тухайн хууль” гэснийг “зөвшөөрсөн бол ажлын 15 өдрийн дотор тухайн болон холбогдох бусад хууль” гэж, 47 дугаар зүйлийн 47.2.4 дэх заалтын “газрын” гэснийг “хорооны” гэж, 50 дугаар зүйлийн 50.1.5 дахь заалтын “1” гэснийг “5” гэж, 53 дугаар зүйлийн 53.7 дахь хэсгийн “хүлээн зөвшөөрөөгүй” гэснийг “хүлээн аваагүй” гэж, мөн зүйлийн 53.10 дахь хэсгийн “хэвлэн нийтлэх бөгөөд түүнийг албан ёсны эх гэж үзнэ.” гэснийг “албан ёсоор нийтэлнэ.” гэж, 54 дүгээр зүйлийн 54.3 дахь хэсгийн “гар /бичгийн/” гэснийг “товч” гэж, мөн зүйлийн 54.6 дахь хэсгийн “гар” гэснийг “товч” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийн “үндэслэлээр төслийг хэлэлцэх боломжгүй гэсэн” гэснийг, 28 дугаар зүйлийн 28.8 дахь хэсгийн “эсхүл” гэснийг, 54 дүгээр зүйлийн 54.8 дахь хэсгийн “ногдол,” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийн 2 дугаар зүйлд заасан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 9¹ дүгээр зүйлийн 9¹.2 дахь хэсэгт оруулсан нэмэлтийг 2019 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 06 дугаар
сарын 29-ний өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэг:

“35.11.Гишүүн нэгдсэн хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй бол тасалсан өдрийн цалинг олгохгүй.”

2/37 дугаар зүйлийн 37.1.11 дэх заалт:

“37.1.11.бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд, эсхүл хуралдаанаас гадуур бусдыг гүтгэж, доромжлох.”

3/39 дүгээр зүйлийн 39.1.16 дахь заалт:

“39.1.16.гишүүн чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдаанд оролцсон ирцийн мэдээг сар бүр гаргаж, олон нийтэд мэдээлэх;”

2 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.16 дахь заалтын дугаарыг 39.1.17 гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 06 дугаар
сарын 29-ний өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 21.14 дэх хэсэг нэмсүгэй:

“21.14.Улсын Их Хурлаас шийдвэр гаргахаар хууль тогтоомжид заасан болон Улсын Их Хурлын үйл ажиллагаа, хуралдааны дотоод зохион байгуулалттай холбоотой хууль тогтоомжийн төсөлд Засгийн газраас санал авахгүй байж болно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 06 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 61

Улаанбаатар
хот

Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид шилжүүлэх эд хөрөнгийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид шилжсэн эд хөрөнгөтэй холбоотой урсгал зардлыг 2018 оны батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



Улсын Их Хурлын 2018 оны 61 дүгээр
тогтоолын хавсралт

**ТӨРИЙН ӨМЧӨӨС АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД ШИЛЖҮҮЛЭХ
ЭД ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

1. Архангай аймаг

мян. төг

Д/д	Байршил	Шилжүүлэх хөрөнгө	Хөрөнгийн нийт (балансын) үнэ	Зориулалт
1	Хайрхан сум	Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн барилга	1,544,581.00	Хүүхдийн цэцэрлэг
2	Эрдэнэбулган сум	Архангай аймгийн Хөдөлмөрийн хэлтэс (хуучин нэрээр)-ийн эзэмшиж байсан автомашин (Лексус 470)	50,000.00	Албан хэрэгцээнд
3	Эрдэнэбулган сум	Архангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгө	133,516.82	Байгаль орчин, байгаль хамгаалал, аялал жуулчлал
4	Эрдэнэбулган сум	Автобус (Хьюндай супер аэросити, 56-73 ДГО)	128,500.00	Албан хэрэгцээнд
	Дүн		1,856,597.82	

2. Баян-Өлгий аймаг

1	Өлгий сум	Худалдааны битүү захын барилгын (60%) хэсэг	1,831,500.00	Худалдааны битүү зах
2	Цагааннуур тосгоноос Улаанбайшинт хүртэлх	Цахилгаан дамжуулах агаарын шугам 10 кВ, 29.7 км, 160, 250 кВа-ын дэд станц	484,798.10	Цахилгаан дамжуулах



3	Цэнгэл сум	ИНЕГ-ын суудлын автомашин (УАЗ-2206, УБИ 09-51)	26,850.00	Албан хэрэгцээнд
	Дүн		2,343,148.10	
3.Баянхонгор аймаг				
1	Баянхонгор сум	Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгө	198,808.56	Байгаль орчин, байгаль хамгаалал, аялал жуулчлал
2	Баянхонгор сум	Баянхонгор аймаг дахь Төрийн банкны барилга (хуучин, 292 м.кв)	81,297.74	Хүүхдийн цэцэрлэг
3	Баянговь сум	ИНЕГ-ын суудлын автомашин (УАЗ-2206, УБИ 01-56)	26,850.00	Албан хэрэгцээнд
4	Баянхонгор сум	Баянхонгор аймгийн Хөдөлмөрийн хэлтэс (хуучин нэрээр)-ийн эзэмшиж байсан автомашин (Хьюндай старекс)	16,000.00	Албан хэрэгцээнд
	Дүн		322,956.30	
4.Булган аймаг				
1	Булган сум	Булган аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгө	465,692.93	Байгаль орчин, байгаль хамгаалал, аялал жуулчлал
2	Булган сум	Булган аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хөдөө аж ахуйн нэвтрүүлэх төвийн 7 нэрийн барилга байгууламж, тээврийн хэрэгсэл	80,055.00	Хөдөө аж ахуйн ололтыг нэвтрүүлэх
	Дүн		545,747.93	

5. Говь-Алтай аймаг				
1	Есөнбулаг сум	Говь-Алтай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгө	409,193.01	Байгаль орчин, байгаль хамгаалал
2	Есөнбулаг сум	Говь-Алтай аймаг дахь Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн хуучин барилга	336,032.80	Хүүхдийн цэцэрлэг
3	Есөнбулаг сум	ИНЕГ-ын суудлын автомашин (УАЗ-2206, УБИ 01-39)	26,850.00	Албан хэрэгцээнд
4	Есөнбулаг сум	Суудлын автомашин (Ланд круйзер 76, УНУ 56-12)	97,900.00	Албан хэрэгцээнд
5	Есөнбулаг сум	Суудлын автомашин (У-62, ГАА 95-59)	90,000.00	Албан хэрэгцээнд
	Дүн		959,975.81	
6. Говь-Сүмбэр аймаг				
1	Сүмбэр сум	Говь-Сүмбэр аймгийн Хөдөлмөрийн хэлтэс (хуучин нэрээр)-ийн эзэмшиж байсан автомашин (Сузуки гранд витара)	48,900.00	Албан хэрэгцээнд
2	Сүмбэр сум	Говь-Сүмбэр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгө	150,646.71	Байгаль орчин, байгаль хамгаалал
3	Баянтал сум	Замын-Үүдийн чөлөөт бүсийн дансанд бүртгэлтэй, 105 дугаар байрны, 5 дугаар орчны, 1-5 дугаар давхрын байр (орон сууц)	169,996.00	Орон нутгийн өмчит компанийг ажлын байраар хангах
	Дүн		369,542.71	

7. Дархан-Уул аймаг				
1	Дархан сум	Дархан-Уул аймаг дахь Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн хуучин барилга	816,809.48	Хүүхдийн цэцэрлэг
2	Дархан сум	Дархан-Уул аймаг дахь Гаалийн газрын хуучин конторын байр (336 м.кв2)	143,808.00	Нутгийн захиргааны байгууллагад конторын зориулалтаар
3	Дархан сум	Дархан үйлдвэрлэл, технологийн паркийн барилга (756 м.кв, 2 давхар барилга)	168,000.00	Үйлдвэрлэл, технологийн парк
4	Дархан сум	“Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын Дархан-Уул аймаг дахь Автотээврийн хэрэгсэл, техник хяналтын төвийн 2 дугаар барилга (хашаа)	321,959.50	Цагдаагийн байгууллагын албан хэрэгцээнд
	Дүн		1,450,576.98	
8. Дорнод аймаг				
1	Хэрлэн сум	Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгө	154,849.15	Байгаль орчин, байгаль хамгаалал
	Дүн		154,849.15	

9.Дундговь аймаг			
1	Сайнцагаан сум	Дорнод аймгийн Хөдөлмөрийн хэлтэс (хуучин нэрээр)-ийн эзэмшиж байсан автомашин (Лексус 470)	43,000.00
2	Сайнцагаан сум	Дундговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгө	316,584.10
3	Сайнцагаан сум	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн (хуучин) байр, дотуур байр (гуанзны барилга) холбогдох инженерийн шугам сүлжээ	1,505,673.20
	Дүн		1,865,257.30
10.Дорноговь аймаг			
1	Сайншанд сум	Дорноговь аймгийн Хөдөлмөрийн хэлтэс (хуучин нэрээр)-ийн эзэмшиж байсан автомашин (Прадо 120)	42,000.00
	Дүн		42,000.00
11.Завхан аймаг			
1	Улиастай сум	Завхан аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгө	122,342.45
2	Улиастай сум	Завхан аймгийн Цагдаагийн газрын ашиглаж буй хуучин Тахарын алба (хуучин нэрээр)-ны 1 давхар барилга	96,360.00
			Байгаль орчин, байгаль хамгаалал Цагдаагийн байгууллагын албан контор



3	Улиастай сум	Завхан аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Цагдах хориор байр	226, 158.80	Цагдаагийн байгууллагын албан хэрэгцээнд
4	Улиастай сум	Завхан аймгийн Хөдөлмөрийн хэлтэс (хуучин нэрээр)-ийн эзэмшиж байсан автомашин (Ланд круйзер 200, 00-06 ЗАН)	68,000.00	Албан хэрэгцээнд
	Дүн		512,861.25	
12.Орхон				
1	Баян-Өндөр сум	Эрдэнэт Үйлдвэрлэл, технологийн паркийн барилга (ХААҮЯ-ны нэр дээр 109 м.кв газартай, 252 м.кв талбайтай)	240,000.00	Үйлдвэрлэл, технологийн парк
2	Баян-Өндөр сум	“Эгийн голын усан цахилгаан станц” ХХК-ийн Орхон аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв ашиглаж буй суудлын автомашин (Ланд круйзер-70, УНД 81-31)	80,000.00	Эмнэлгийн үйлчилгээнд
	Дүн		320,000.00	
13.Өвөрхангай аймаг				
1	Арвайхээр сум	Өвөрхангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгө	70,909.10	Байгаль орчин, байгаль хамгаалал

2	Арвайхээр сум	Өвөрхангай аймгийн Прокурорын газрын суудлын машин (Тобота чейзер, 38-83 ӨВР)	10,000.00	Албан хэрэгцээнд
	Дүн		80,909.10	
14.Өмнөговь аймаг				
1	Даланзадгад сум	Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгө	119,884.63	Байгаль орчин, байгаль хамгаалал
2	Даланзадгад сум	Өмнөговь аймгийн Хөдөлмөрийн хэлтэс (хуучин нэрээр)-ийн эзэмшиж байсан автомашин (Ланд крузер 100)	43,000.00	Албан хэрэгцээнд
3	Гурвантэс	ИНЕГ-ын суудлын автомашин (УАЗ-2206, УБИ 31-86)	26,850.00	Албан хэрэгцээнд
	Дүн		189,734.63	
15.Сүхбаатар аймаг				
1	Баруун-Урт сум	Сүхбаатар аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгө	47,971.59	Байгаль орчин, байгаль хамгаалал
	Дүн		47,971.59	

16.Сэлэнгэ аймаг				
1	Сүхбаатар сум	Сэлэнгэ аймгийн Хөдөлмөрийн хэлтэс (хуучин нэрээр)-ийн эзэмшиж байсан автомашин (Лексус 470)	65,000.00	Төрийн үйлчилгээнд
2	Мандал сум	“Хүлэмж, зоорийн аж ахуйн цогцолбор”	2,895,784.71	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх
3	Сүхбаатар сум	ИНЕГ-ын суудлын автомашин (УАЗ-2206, УБИ 01-21)	26,850.00	Төрийн үйлчилгээнд
4	Сүхбаатар сум	Суудлын автомашин (Ланд круйзер 78, УНУ 56-05)	87,000.00	Төрийн үйлчилгээнд
	Дүн		3,074,634.71	
17.Төв аймаг				
1	Зуунмод сум	Дундговь аймгийн Хөдөлмөрийн хэлтэс (хуучин нэрээр)-ийн эзэмшиж байсан автомашин (Форд экспедишн, ДУА 95-99)	44,000.00	Төрийн үйлчилгээнд
3	Зуунмод сум	ИНЕГ-ын суудлын автомашин (УАЗ-2206, УБИ 01-21)	26,850.00	Төрийн үйлчилгээнд
	Дүн		70,850.00	

18. Увс аймаг			
1	Улаангом сум	Увс аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгө	196,123.18 Байгаль орчин, байгаль хамгаалал
2	Улаангом сум	Бизнес инкубатор төвийн барилга	330,000.00 Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх
3	Улаангом сум	Увс аймгийн Хөдөлмөрийн хэлтэс (хуучин нэрээр)-ийн эзэмшиж байсан автомашин (Ландкрузер 80)	39,900.00 Төрийн үйлчилгээнд
4	Улаангом сум	“Баруун бүсийн эрчим хүчний систем” ХК-ийн эзэмшлийн суудлын автомашин (Ланд круйзер 200)	88,544.40 Төрийн үйлчилгээнд
5	Улаангом сум	Худалдааны битүү захын барилга	3,052,500.00 Худалдааны битүү зах
6	Улаангом сум	“Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын Увс аймаг дахь уурын зуухны барилга	44,475.90 Орон нутгийн дэд бүтцийг сайжруулах
	Дүн		3,751,543.48
19. Ховд аймаг			
1	Жаргалант сум	Ховд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгө	53,054.25 Байгаль орчин, байгаль хамгаалал
2	Жаргалант сум	Ховд аймгийн Хөдөлмөрийн хэлтэс (хуучин нэрээр)-ийн эзэмшиж байсан автомашин (Ландкрузер 100)	44,000.00 Төрийн үйлчилгээнд

3	Жаргалант сум	Худалдааны битүү захын барилга	3,663,000.00	Худалдааны битүү зах
4	Жаргалант сум	Мэргэжлийн хяналтын газрын барилга (хуучин)	167,328.00	Албан контор
5	Жаргалант сум	Ховд аймгийн Шүүхийн тамгын газрын эзэмшилд байгаа Хүүхдийн 14 дүгээр цэцэрлэгийн агуулахын зориулалтаар ашиглаж буй гараашийн барилга	2,265.50	Хүүхдийн цэцэрлэгийн агуулах
	Дүн		3,929,647.75	

20.Хөвсгөл аймаг

1	Мөрөн сум	Хөвсгөл аймгийн Хөдөлмөрийн хэлтэс (хуучин нэрээр)-ийн эзэмшиж байсан автомашин (Ландкрузер 105)	67,800.00	Төрийн үйлчилгээнд
2	Мөрөн сум	Хөвсгөл аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгө	742,725.49	Байгаль орчин, байгаль хамгаалал
3	Мөрөн сум	Хөвсгөл аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 443 дугаар хорих ангийн цагдан хорих байр, хашааны хамт	17,263.60	Цагдаагийн байгууллагын албан хэрэгцээнд
	Дүн		827,789.09	

21. Хэнтий аймаг				
1	Хэрлэн сум	Хэнтий аймгийн Хөдөлмөрийн хэлтэс (хуучин нэрээр)-ийн эзэмшиж байсан автомашин (Ландкрузер 105)	68,000.00	Төрийн үйлчилгээнд
2	Хэрлэн сум	Хэнтий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгө	160,189.66	Байгаль орчин, байгаль хамгаалал
	Дүн		228,189.66	
22. Нийслэл Улаанбаатар хот				
1	Баянзүрх дүүрэг	Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн 2655 метр зам, дугуйн зогсоол	3,579,922.10	Нийтийн хэрэгцээнд ашиглах
2	Баянзүрх дүүрэг	Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн спорт цогцолбор	1,429,222.30	Нийтийн хэрэгцээнд ашиглах
3	Багануур дүүрэг	Үйлдвэрлэл, технологийн паркийн барилга	175,000.00	Үйлдвэрлэл, технологийн парк
4	Баянзүрх дүүрэг	ЦЕГ-ын харьяа 805 дугаар ангийн эзэмшилд байсан эд хөрөнгө	7,813.96	Төрийн үйлчилгээнд
	Дүн		5,191,958.36	
	НИЙТ ДҮН		28,136,741.71	

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 06 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 62

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Их Хурлын сонгуулийн
42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон
зарлах, санал авах өдрийг тогтоох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Сонгуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт явагдах Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэхээр товлон зарласугай.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт явагдах Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийн санал авах ажиллагааг 2018 оны 10 дугаар сарын 07-ны өдөр явуулахаар тогтоосугай.

3. Энэ тогтоолыг 2018 оны 06 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 06 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 63

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Их Хурлын сонгуулийн
42 дугаар тойргийн нөхөн сонгуульд
техник хэрэгсэл хэрэглэх тухай**

Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт явагдах Монгол Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийн сонгогчдын бүртгэлийн үйл ажиллагаанд бүртгэлийн техник хэрэгслийг, санал авах, тоолох, дүн гаргах үйл ажиллагаанд “New Image Cast” санал тоолох төхөөрөмжийг тус тус хэрэглэхийг зөвшөөрсүгэй.



2.Энэ тогтоолыг 2018 оны 06 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 06 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 64

Улаанбаатар
хот

**Нөхөн болон дахин сонгуулийн
зардлын хэмжээг батлах тухай**

Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт явагдах Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг 228 095 885 /хоёр зуун хорин найман сая ерэн таван мянга найман зуун наян тав/ төгрөгөөр, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн, дахин сонгуулийг зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг 162 537 250 /нэг зуун жаран хоёр сая таван зуун гучин долоон мянга хоёр зуун тавь/ төгрөгөөр баталсугай.

2.Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай.

3.Энэ тогтоолыг 2018 оны 06 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 06 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 65

Улаанбаатар
хот

Түр хорооны даргыг сонгох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар



зүйлийн 15.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Цахим бодлогын түр хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учралыг сонгосугай.

2.Энэ тогтоолыг 2018 оны 06 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 06 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 66

Улаанбаатар
хот

Прокурорын зэрэг дэвийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.3 дахь заалт, 28.7 дахь хэсэг, Прокурорын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Прокурорын зэрэг дэвийн нэмэгдлийн хэмжээ”-г хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан “Прокурорын зэрэг дэвийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын 2007 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 35 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.

3.Энэ тогтоолыг 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

Монгол Улсын Их Хурлын 2018 оны
66 дугаар тогтоолын хавсралт

**ПРОКУРОРЫН ЗЭРЭГ ДЭВИЙН
НЭМЭГДЛИЙН ХЭМЖЭЭ**

Зэрэг дэв	Төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх	Төрийн хууль цаазын шадар зөвлөх	Хууль цаазын тэргүүн зөвлөх	Хууль цаазын шадар зөвлөх	Хууль цаазын итгэмжит зөвлөх	Хууль цаазын ахлах зөвлөх	Хууль цаазын зөвлөх	Хууль цаазын дэд зөвлөх
Нэмэгдлийн хувь	33.0	31.0	29.0	27.0	26.0	25.0	24.0	23.0

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 06 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 67

Улаанбаатар
хот

**Монгол Улсын 2017 оны төсвийн
гүйцэтгэл батлах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын 2017 оны төсвийн гүйцэтгэлийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 5,173,682.6 сая /таван их наяд нэг зуун далан гурван тэрбум зургаан зуун наян хоёр сая зургаан зуун мянган/ төгрөгөөр баталсугай.

2.Монгол Улсын 2017 оны төсвийн гүйцэтгэлийн зарлагын /тэнцвэржүүлсэн орлогод нийцүүлсэн/ хэмжээг 7,139,637.5 сая /долоон их наяд нэг зуун гучин есөн тэрбум зургаан зуун гучин долоон сая таван зуун мянган/ төгрөгөөр баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 06 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 68

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2018 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Валютын зохицуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон түүнтэй хамт өргөн мэдүүлсэн Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хэлэлцэхийг дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 06 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 69

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганаар дараах асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсүгэй:

1/Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн төсөл;

2/Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хуулийн төсөл;

3/Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хуулийн төсөл;

4/“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэлийг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

5/Татварын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл;

6/Аж аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл;



7/Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл;

8/Хувь хүний орлогын албан татварын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл;

9/Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл;

10/Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

11/Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

12/Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл;

13/Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл;

14/Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөл;

15/Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл;

16/Улс төрийн намын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

17/Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл;

18/Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл;

19/Нөхөн үржихүйг дэмжих зохицуулалтын тухай хуулийн төсөл;

20/Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

21/Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

22/Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуулийн төсөл;

23/Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

24/бусад.



2.Хэлэлцүүлгийн шатанд байгаа болон Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурлын гишүүд, Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн энэ тогтоолын 1-д зааснаас бусад хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудлыг тухай бүрд нь шийдвэрлэж байхаар тогтоосугай.

3.Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хууль санаачлагчаас өргөн мэдүүлбэл намрын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын дараалалд оруулахыг Монгол Улсын Их Хурлын дарга /М.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

4.Монгол Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Монгол Улсын Их Хурлын Байнгын хороод, Монгол Улсын Их Хурал дахь намын бүлгүүд, Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, Монгол Улсын Их Хурлын Тамгын газар /Ц.Цолмон/-т тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 06 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 70

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зарим заалтыг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан доор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Их Хурлын Тамгын газар /Ц.Цолмон/-т даалгасугай:

1/Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд санал хураалт явуулахад ашиглах биеийн давхцахгүй өгөгдөл

/гарын хурууны хээ/-өөр идэвхэждэг систем бүхий төхөөрөмжийг Байнгын хороодын болон нэгдсэн хуралдааны танхимд суурилуулах;

2/Биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-өөр идэвхэждэг систем бүхий төхөөрөмжийг худалдан авах, суурилуулахтай холбогдон гарах зардлыг Улсын Их Хурлын төсвөөс гаргах.

2.Энэ тогтоолыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 06 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 71

Улаанбаатар
хот

**“Төрөөс төмөр замын тээврийн талаар
баримтлах бодлого батлах тухай”
Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар
тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай**

Төмөр замын тээврийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын 2010 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 32 дугаар тогтоолын хавсралтын “Гурав”-ын 3.2.4 дэх заалтад доор дурдсан агуулгатай 3.2.4.5, 3.2.4.6 дахь дэд заалт нэмсүгэй:

“3.2.4.5.Зүүнбаян - Ханги - 280 км;
3.2.4.6.Эрдэнэт - Арцсуурь - 780 км.”

2.“Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2010 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 32 дугаар тогтоолын хавсралтын “Гурав”-ын 3.2.4 дэх заалтын “нийт 900 орчим км” гэснийг “нийт 1900 орчим км” гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 06 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 72

Улаанбаатар
хот

**“Төрөөс иргэний нисэхийн салбарт
2020 он хүртэл баримтлах бодлого батлах тухай”
Улсын Их Хурлын 2013 оны 18 дугаар
тогтоолын хавсралтад өөрчлөлт
оруулах тухай**

Иргэний нисэхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын 2013 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 18 дугаар тогтоолын хавсралтын “Гурав”-ын 3.8, 3.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3.8.Агаарын тээврийн зах зээлийг үе шаттай чөлөөлж, чөлөөт өрсөлдөөнийг дэмжих зорилгоор олон улсын нислэгийн шугамыг хуваарилахдаа нислэгийн давтамжийг суудлын багтаамжтай уялдуулах чиглэл баримтална.

3.9.Гадаад улсаас Монгол Улс руу хуваарьт нислэг үйлдэх тээвэрлэгчийн тухайд зах зээлийн эрэлт хэрэгцээг харгалзан, ижил тэнцүү орчинд өрсөлдөх, үндэсний агаарын тээвэрлэгчийн өрсөлдөх чадварыг сайжруулах чиглэл баримтална.”

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 06 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 73

Улаанбаатар
хот

**Тавантолгойн нүүрсний ордын үйл
ажиллагааг эрчимжүүлэх талаар авах
зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Тавантолгойн нүүрсний ордын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, холбогдох дэд бүтцийг барьж байгуулах зорилгоор дараах

арга хэмжээг хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай:

1/Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 2 дахь дэд заалтын “б”, “в”-д заасны дагуу стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр арилжаалан, шаардлагатай хөрөнгө оруулалтыг татсаны үндсэн дээр Тавантолгойн ордын үнэ цэнийг өсгөх хүрээнд холбогдох дэд бүтцийн болон шаардлагатай бусад төсөл, хөтөлбөрийн тодорхой хэсгийг санхүүжүүлэх;

2/Тавантолгой - Гашуунсухайт, Тавантолгой - Зүүнбаян, Тавантолгой - Оюутолгой - Ханги, Тавантолгой - Барууннаран чиглэлийн авто замын төгсгөлөөс Цагаандэл уул чиглэлийн тусгай зориулалтын авто зам болон Тавантолгой - Гашуунсухайт, Тавантолгой - Зүүнбаян чиглэлийн төмөр зам зэрэг төслийг эхлүүлэх талаар шуурхай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3/дамжин өнгөрөх тээвэр, угтуулан тавих нөхцөл, урьдчилгаа төлбөр, боомт ашиглалт, дэд бүтцийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, борлуулалтын нөхцөлийн талаар хөрш орнуудтай хэлэлцээ хийж хэрэгжүүлэх;

4/өмнөд бүсийн уул уурхайн төслүүдийн эрчим хүчний хэрэгцээг хангах цахилгаан станц болон нүүрс химийн үйлдвэрийг Тавантолгойн ордыг түшиглэн барих талаар шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

5/Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээтэй уялдуулан өмнийн говийн бүтээн байгуулалтад шаардагдах усан хангамжийн найдвартай эх үүсвэрийг хангах ажлын хүрээнд гадаргын болон гүний усыг байгаль, экологийн тэнцвэрийг алдагдуулахгүйгээр зохистой ашиглах боломжийг судлан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

6/энэ тогтоолын 1 дэх заалтын 1 дэх дэд заалтад тусгагдсан биржээр арилжаалах бэлтгэл ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, 2018 онд багтаан Улсын Их Хуралд танилцуулах, шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;



2.Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын 3.2.4.2 дахь дэд заалтын “Ухаа худаг” гэснийг “Тавантолгой” гэж, Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 1 дэх заалтын “Дайцуки ХХК-ийн” гэснийг “Эрдэнэс Тавантолгой ХК”-ийн” гэж тус тус өөрчилж, Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 1 дэх дэд заалтаас “охин” гэснийг болон “орд ашиглалтын тусгай зөвшөөрлийг хуваахгүйгээр шилжүүлэх, түүнтэй хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах,” гэснийг хасаж, Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 3, 5 дахь дэд заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 2,75

Индекс: 200003